*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ САНСРЫН ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ С.ОНОНЧИМЭГИЙН 2025 ОНЫ II УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дуусах хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. “Үндэсний радио давтамжийн нөөцийг үр ашигтай, зүй зохистой ашиглах, шударга, тэгш хуваарилах ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг хангах”** | | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Монгол Улсын Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд WRC-23 хурлын шийдвэрийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, батлуулах | Гүйцэтгэлийн хувь | Дэлхийн радио холбооны дүрмийн шинэчлэлийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. | 100% | - | **Биелэлт:** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2025.03.10-ны өдрийн А/46 дугаар тушаалаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг баталж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлийн 2025.03.27-ны өдрийн 7178 дугаар бүртгүүлсэн. | 2025.01-2025.03 | 100% |
| | **Дэд арга хэмжээ 1.1.1** Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд байгууллагуудаас ирүүлсэн саналыг хэлэлцүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулах | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 50% | 50% | - | **Биелэлт:** Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн төслийг боловсруулж, радио давтамж эзэмшигч төр, хувийн хэвшлийн байгууллагуудын дунд танхимаар 2025.02.05, 2025.02.24-ний өдрүүдэд хэлэлцүүлж, албан бичгээр 1 удаа, цахимаар 1 удаа санал авч хэлэлцүүлсэн. | 2025.01 | 100% |
| | **Дэд арга хэмжээ 1.1.2** Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн нэмэлт, өөрчлөлтийг сайдаар батлуулах | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 45% | - | **Биелэлт:** “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын | 2025.02-2025.03 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025.03.10-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлуулсан. | | |
| | **Дэд арга хэмжээ 1.1.3** Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 5% | - | **Биелэлт:** "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт"-ийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр танилцуулга, нөлөөллийн шинжилгээг хийж 2025.03.12-ны өдрийн 03/570 албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлж, 2025.03.27-ны өдрийн 7178 дугаарт бүртгүүлсэн. Захиргааны хэм, хэмжээний актын нэгдсэн сайтад legalinfo.mn сайтад байршсан. | 2025.03 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Дэлхийн радио холбооны их хурал /WRC-27/-д бэлтгэх Ази, Номхон далайн бүсийн ээлжит бэлтгэл хурал (APG27-2)-аар хиймэл дагуулын сүлжээний болон утасгүй газрын сүлжээний зохицуулалтад орохоор хэлэлцэгдэж байгаа өөрчлөлтийг судлах, санал боловсруулах, хурлаар хэлэлцүүлэх | Гүйцэтгэлийн хувь | Дэлхийн радио холбооны их хурал (WRC) 3-4 жилд 1 удаа, Бүсийн бэлтгэл хурал (APG) жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулагддаг. | 80% | 20% | **Биелэлт:**1.Дэлхийн радио холбооны их хурал (WRC-27)-д бэлтгэх Ази, Номхон далайн бүсийн ээлжит бэлтгэл хурал (APG27-1)-аар хэлэлцсэн хиймэл дагуулын үйлчилгээ болон утасгүй газрын сүлжээний зохицуулалтад орохоор хэлэлцэгдэж байгаа өөрчлөлтийг судалсан. 2. WRC-27 хурлын CPM27-1-д тусгагдсан хиймэл дагуулын үйлчилгээ болон утасгүй газрын сүлжээний зохицуулалтад орохоор хэлэлцэгдэж байгаа өөрчлөлтийг судалж байна. APG27-2 хурал 2025.07.28-2025.08.01-ний өдрүүдэд зохион байгуулагдахаар товлогдсон. | 2025.05-2025.06 | 50% |
| 3. | **Арга хэмжээ 1.3** Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийг шинэчлэн боловсруулах | Гүйцэтгэлийн хувь | Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025)-ийг 2020 онд баталсан. | 20% | 80% | **Биелэлт:** Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж гаргасан. | 2025.05-2025.06 | Тайлант хугацаа болоогүй |
| | **Дэд арга хэмжээ 1.3.1** Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020- | Үндсэн арга хэмжээний | - | 100% | - | **Биелэлт:** 1.Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-д туссан яамны хариуцсан ажлын | 2025.06 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2025 он)-ийн хэрэгжилтийг гаргах | гүйцэтгэлд эзлэх хувь | | | | хэрэгжилтийн тайланг гаргасан. 2.ХХЗХ-ны хариуцах ажлын хэрэгжилтийн тайланг 2025.04.22-ны өдрийн 05/777 албан бичгээр хүлээн авсан. (Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.03-ны өдрийн 02/737 дугаар албан бичиг хүргүүлсэн.) | | |
| | **Дэд арга хэмжээ 1.3.2** Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийг шинэчлэх судалгаа хийх | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | - | 20% | 80% | **Биелэлт:** Монгол Улсын радио давтамжийн дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийг шинэчлэх судалгааны хүрээнд олон улсын судалгааг эхлүүлсэн. Үүнд: Австрали улсын туршлагыг судалж байна. | 2025.05-2025.06 | Тайлант хугацаа болоогүй |
| 4. | **Арга хэмжээ 1.4** Радио долгионы тухай хуулийг дагаж гарсан захиргааны хэм хэмжээний актуудад дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах | Гүйцэтгэ-лийн хувь | Радио долгионы тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2024 онд үнэлгээ хийсэн. | 40% | 60% | **Биелэлт:** Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй (ЗГХЭГ-ын 2025.05.13-ны ХЭГ/1370 албан бичгээр ирүүлсэн) холбогдуулан Радио долгионы тухай хуульд оруулах зөвшөөрөлтэй холбоотой асуудлын төслийг судалж, холбогдох мэдээллийг Хуулийн хэлтэст хүргүүлсэн ба 2025.05.22, 2025.05.29-ний уулзалтад оролцож, хүргүүлсэн саналын талаар хэлэлцсэн. | 2025.05-2025.06 | Тайлант хугацаа болоогүй |
| 5. | **Арга хэмжээ 1.5** Төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах | Хамтран ажилласан эсэх (тийм: 1/ үгүй: 0) | 1 | 1 | 1 | **Биелэлт:** Харилцаа холбооны зохицуулах хороо, үйлчилгээ эрхлэгчидтэй холбогдох чиглэлээр хамтран ажиллаж байна. | 2025.01-2025.06 | - |
| | **Дэд арга хэмжээ 1.5.1** Дэлхийн Радио холбооны дүрэм (ITU RR2024)-ийн 4 боть номыг англи хэлнээс монгол хэл рүү орчуулах ажлыг ХХЗХ-той хамтран зохион байгуулах | Ажлын даалгавар боловсруулсан эсэх (тийм: 1/ үгүй: 0) | - | 1 | - | **Биелэлт:** Дэлхийн радио холбооны Дүрэм орчуулах ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, ХХЗХ-нд 2025.04.01-ний өдрийн 03/702 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 2025.02-2025.06 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Дэд арга хэмжээ 1.5.2** Дэлхийн Радио холбооны дүрэм (ITU RR2024)-ийн 4 боть номын орчуулгыг хянах, хүлээн авах, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах | Гүйцэтгэлийн хувь | - | 40% | 60% | **Биелэлт:** Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны төсөвт энэ ажлын санхүүжилт тусаагүй тул, ЗГХЭГ тус хорооны төсөвт өөрчлөлт оруулах ажил хийгдсэний дараа зарлагдах болсон тул уг ажил сүүлийн хагас жилд хийгдэхээр хойшлуулсан. | 2025.05-2025.06 | Хойш-логдсон |
| **Зорилт 2. "Хил залгаа улстай радио долгионы асуудлыг зохицуулах"** | | | | | | | | |
| 8. | **Арга хэмжээ 2.1** Хөрш орнуудтай байгуулсан хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын гэрээний хэрэгжилтийг хангах | Координац хийсэн эсэх (тийм: 1/ үгүй: 0) | 1 | 1 | 1 | **Биелэлт:** 1.ОХУ, БНХАУ, Казакстан Улсын холбогдох яамдтай хил орчмын радио давтамжийн зохицуулалтын координацыг тухай бүр хийсэн.<br>2.ОУЦХБ-ын Олон улсын Радио давтамжийн Мастер Бүртгэлд ХХЗХ-ноос бүртгүүлсэн газрын хөдөлгөөнт холбооны 99, хөдөлгөөнт холбооны 24, газрын хөдөлгөөнт холбооны 100 станцын мэдээллийг баталгаажуулж, 2025.01.09-ний MDDIC/03/05, 2025.01.23-ны MDDIC/03/16 албан бичгээр тус тус ОУЦХБ-д хүргүүлсэн.<br>3.Казакстан улсаас ирүүлсэн хиймэл дагуулын газрын станцын координац хийх тухай 3 албан хүсэлтэд холбогдох хариуг тухай бүр хүргүүлсэн. | 2025.01-2025.06 | 100% |
| | | ОХУ-тай хийсэн координацийн тоо | 20 | 10 | 10 | **Биелэлт:** 1.Хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээний дагуу ОХУ-ын Радио давтамжийн төвөөс ирүүлсэн газрын хөдөлгөөнт холбооны 4 станцын, хөдөлгөөнт бус үйлчилгээний 9 станцын, VHF/FM өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний 1 станцын, хиймэл дагуулын газрын 2 станцын, нийт **16** станцын координац хийсэн.<br>2.Хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээний дагуу | 2025.01-2025.06 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсаас ОХУ-тай хөдөлгөөнт холбооны 5G үйлчилгээний (3350МГц, 3450МГц, 3650МГц, 3750МГц) станц, FM (88.3 МГц) өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний станцын координац хийх тухай албан хүсэлтийг ОХУ-ын талд тус тус хүргүүлсэн. | | |
| | | БНХАУ-тай хийсэн координацийн тоо | 2 | 1 | 1 | **Биелэлт:** Замын-Үүд боомтод БНХАУ-ын талаас 2500-2600 МГц радио давтамжийн зурваст үүсгэж байгаа радио давтамжийн харилцан нөлөөллийн талаарх мэдэгдлийг БНХАУ-ын талд 2025.05.14-ний өдрийн MDDIC/03/78 албан бичгээр, хэмжилтийн тайлангийн хамт хүргүүлсэн. | 2025.01-2025.06 | 100% |
| **Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | | |
| 9. | **Арга хэмжээ 3.1** Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх, ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | Хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн эсэх (тийм: 1 / үгүй: 0) | 1 | 1 | 1 | **Биелэлт:** 1.Яамны 2022-2024 оны стратеги төлөвлөгөөнд туссан нэгжийн төлөвлөгөөний биелэлтийг гаргасан.<br>2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-т туссан 5G технологитой холбоотой ажлын хэрэгжилтийг гаргаж ХШҮДАГ-т хүргүүлсэн. | 2025.02-2025.06 | 100% |
| | | Хугацаандаа шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | Тухай бүр | Тухай бүр | Тухай бүр | **Биелэлт:** Ондо ХХК-ийн нэхэмжлэхтэй холбоотой Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ирүүлсэн нотлох баримт гаргуулах тухай 2025.01.31-ний 1/296 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг 2025.02.06-ны өдрийн 03/269 дугаар албан бичгээр Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлсэн. | 2025.01-2025.06 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | **Арга хэмжээ 3.2** Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг өгөх | Хөрөнгө, орлогын мэдүүлгээ цаг тухайд нь мэдүүлсэн эсэх | Тухай бүр | Тухай бүр | Тухай бүр | **Биелэлт:** 1.2024 оны ХАСХОМ-ийг мэдүүлж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. | 2025.01-2025.06 | 100% |
| 11. | **Арга хэмжээ 3.3** Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, тайлан гаргах, байгууллагуудаас ирүүлсэн албан бичигтэй тухай бүрд нь танилцаж, хариу хүргүүлэх | Төлөвлөгөө, тайлан гаргасан эсэх | Тухай бүр | Тухай бүр | Тухай бүр | **Биелэлт:** 1.ТЖАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, нэгжийн даргаар баталгаажуулсан.<br>2.2025 оны 1 улирлын нэгжийн тайланг гаргасан.<br>3.ТЖАХ-ийн 2025 оны 2-р улирлын гүйцэтгэлийн тайланг гаргаж, нэгжийн даргаар үнэлгээ хийлгэсэн. | 2025.01-2025.06 | 100% |
| | | Албан бичигт тухай бүрд нь хариу хүргүүлсэн эсэх | Тухай бүр | Тухай бүр | Тухай бүр | **Биелэлт:** Дотоод 11 албан бичигт, гадаад 25 албан бичигт хариу хүргүүлэн ажилласан. | 2025.01-2025.06 | 100% |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар 1.** Ажлын хэсэгт ажиллах | Үнэлгээ хийлгэсэн эсэх | - | 1 | **Биелэлт:** 1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2025.02.28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулсан "Хөдөлгөөнт холбооны 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд 2G/3G сүлжээг хэрхэн зогсоосон талаарх олон улсын судалгааг хийж, ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлсэн.<br>2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2025 оны А/48 дугаар тушаалаар | 2025.02-2025.06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан "Дроны туршилтын бүсийг байгуулах" ажлын хэсгийн хуралд 2025.04.09-ний өдөр хамрагдаж, Дроны туршилтын бүс байгуулахаар сонгож байгаа Хонхорын станцын байршилд радио давтамжийн харилцан нөлөөлөл үүсгэж, цаашдын үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй талаар мэдээлэл өгсөн.<br>3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/62 дугаар тушаалаар байгуулсан "Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологийг ашиглан жолоочгүй тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэх нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд Шивээхүрэн боомт дээр 5G технологийн туршилт хийхэд ашиглах туршилтын радио давтамжийг тодорхойлохоор холбогдох хурлуудад хамрагдсан. | | |
| 2. | **Үүрэг даалгавар 2.** Салбарын хууль, тогтоомжийг 2025-2026 онд боловсронгуй болгох үндсэн чиглэлд санал хүргүүлэх | Тандан судалгаа хийлгэсэн эсэх | - | 1 | **Биелэлт:** Салбарын хууль, тогтоомжийг 2025-2026 онд боловсронгуй болгох үндсэн чиглэлд Радио долгионы тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн санал, Сансрын тухай анхдагч хуулийг боловсруулах үндэслэл, шаардлагыг боловсруулж Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | 2025.04 | 100% |
| 3. | **Үүрэг даалгавар 3.** "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн | Мод тарьсан эсэх | 1 | 1 | **Биелэлт:** "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд яамны мод тарих багт орон зэвсэгт хүчний мод үржүүлгийн талбайд 2025.05.10-ны өдөр мод тарьсан. | 2025.05 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | Хүрсэн түвшин | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Төрийн захиргааны болон мэргэшлийн холбогдох сургалтад хамрагдах | Холбогдох сургалтад тухай бүрд хамрагдсан эсэх<br>(тийм: 1 / үгүй: 0) | 1 | 1 | 1 | 1.НҮБ-ын Сансрын асуудал хариуцсан байгууллага ба ОУЦХБ-аас хамтран 2025.06.04-06.05-ны өдрүүдэд зохион байгуулсан "From an ITU Filling to registration with UNOOSA – The | 2025.01-2025.06 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Life Cycle of a Satellite” сэдэвт сургалтад цахимаар хамрагдсан.<br>2.Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 эрх авах сургалтад хамрагдсан. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Эрхэлсэн ажлын чиглэлээр зохион байгуулагдах хурал, сургалт, семинарт хамрагдах | Холбогдох хурал, сургалт, семинарт тухай бүрд оролцсон эсэх<br>(тийм: 1 / үгүй: 0) | 1 | 1 | 1 | 1. Хуулийн хэлтсээс Салбарын хуульчдын дунд 2025.01.21-ний өдөр зохион байгуулсан Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Сансрын тухай анхдагч хуулийн талаар уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон.<br>2.Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2025.04.17-ны өдөр зохион байгуулсан "Харилцаа холбооны хиймэл дагуулын бодлого, зохицуулалт" арга хэмжээнд оролцсон. | 2025.01-2025.06 | 100% |
| 3 | **Арга хэмжээ 3.** Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 эрх авах | Сертификат авсан эсэх<br>(тийм: 1 / үгүй: 0) | - | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 2025.04-2025.06 | - |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Шинжээч | ........................... /С.Онончимэг / | ......... ......... ......... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |